

ХЭФ-ын бүх гишүүдийн 2018 оны 6-р сарын хурлаар батлав.

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Ёс зүйн дүрэм зөрчсөн Форумын гишүүн байгууллага, тухайн байгууллагыг төлөөлж буй хүний асуудлыг Форумын Ёс зүйн Зөвлөлийн хурлаар хэлэлцэх, Ёс зүйн хариуцлага хүлээлгэх ажиллагааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.
- 1.2. Ёс зүйн Зөвлөлийн үйл ажиллагаанд энэ журам, Форумын дотоод дүрэм, Ёс зүйн дүрмийг баримтална.

Хоёр. Ёс зүйн зөвлөлийн зохион байгуулалт

- 2.1. Ёс зүйн дүрмийн 3.1-д заасны дагуу 3 гишүүнийг Форумын хурлаас байгуулна.
- 2.2. Ёс зүйн Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох хурлын тэмдэглэлийг хөтөлнө. Уг тэмдэглэл нь Форумын хуралдааны дэгийг шаардлагыг хангасан байна.

Гурав. Ёс зүйн зөвлөлийн эрх, үүрэг

- 3.1. Ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж гомдол гаргасан байгууллага, хувь хүн болон гомдоогч гэх талуудыг тэнцүү оролцоотой байлцуулан, бичгээр ирсэн Гомдлыг хэлэлцэж, байгууллагатай холбоотой асуудлыг илээр, хувь хүнтэй холбоотой асуудлыг нууцаар санал хураан шийдвэр гаргана.
- 3.2 Шийдвэрийг талуудад биечлэн танилцуулж, гомдол барагдуулна.
- 3.3. Ёс зүйн дүрмийн 3.6-д заасан хариуцлагын асуудлыг Форумын бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэнэ.

Дөрөв. Ёс зүйн үйл ажиллагааны дэг

- 4.1. Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэх хүсэлтийг бичгээр авна.
- 4.2. Ёс зүйн зөвлөл нь бүрэн бүрэлдэхүүнээр хуралдана.
- 4.3 Ёс зүйн зөвлөлөөр асуудлал хэлэлцэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гишүүд оролцоно. Шаардлагатай үед Форумын хурлаар Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг томилно.

Тав. Ёс зүйн гишүүнд хүлээлгэх хариуцлага

- 5.1 Ёс зүйн зөвлөлийн гишүүд Форумын дүрэм, түүний Ёс зүйн зарчмыг баримтална. Хэрэв эдгээр зарчмын гишүүд зөрчвөл Ёс зүйн зөвлөлөөс гаргана.